

# “МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 10-ны өдөр

№ 06/05

Улаанбаатар хот

“Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам” батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодексе”, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дугаар заалт зэргийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-д тодорхойлсон эрх бүхий албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үүсэн тохиолдолд харилцааг зохицуулсан “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг Хавсралт №01-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийг ханган, компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ байнга мөрдөж ажиллахыг Монос хүнс ХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Х.АНАНД

Л.ХҮРЭЛБААТАР

Ч.БАТТОГТОХ

Б.ГАНТУЛГА

О.ЛХАГВАСҮРЭН

Х.СОЛОНГО

Ц.ЦЭЦЭГБАДАМ

А.ОТГОНДАРЬ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн  
02.1.25 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт



## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

[КОМПАНИЙН ХЭРЭГЦЭЭНД]

Баримт бичгийн төрөл:	Журам
Хамрах хүрээ:	ТУЗ-ийн гишүүд
Хувийг хадгалах:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Баталсан:	Х.Ананд /ТУЗ-ийн дарга/
Хуудасны тоо:	..... хуудас
Батлагдсан огноо:	2023 оны 05 дугаар сарын 10
Шинэчилж сайжруулсан огноо:	..... оны ..... дугаар сарын ....



**АГУУЛГА**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР. НЭР ТОМЬЁО**

**ГУРАВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАХ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ**

**ДӨРӨВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ МЭДЭГДЭХ, ТАЙЛБАРЛАХ, ЗОХИЦУУЛАХ**

**ТАВ. БУСАД ЗҮЙЛ**

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Монос Хүнс” ХК-ийн (цаашид “компани” гэх) стратегийн болон үйл ажиллагааны зорилго зорилгоо биелүүлэх явцад үүсэж болох ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад оршино.
- 1.2. Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, компанийн эрх бүхий албан тушаалтан /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/-уудын хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, ашиг сонирхлын зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил бий болсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ журамд заасан эрх бүхий албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 1.4. Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

## ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. “**Ашиг сонирхлын зөрчил**” гэдэгт компанийн эрх бүхий албан тушаалтан хууль болон гэрээгээр олгогдсон эрхээ хэрэгжүүлэх явцад түүний хувийн ашиг сонирхол компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ үнэнч, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ойлгоно.
- 2.2. “**Эрх бүхий албан тушаалтан**” буюу мэдүүлэг гаргагч гэдэгт компанийн дүрмийн 9-р зүйлийн 9.1-д заасан ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, үйл ажиллагаа хариуцсан захирал, санхүү хариуцсан захирал, ерөнхий нягтлан бодогч зэрэг компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон этгээдүүдийг хамааруулна.
- 2.3. “**Хамаарал бүхий этгээд**” гэдэгт компанийн эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий эцэг, эх, төрсөн ах дүү, эгч, гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч, эхнэр/нөхөр/, тэдний эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно.
- 2.4. “**Нэгдмэл сонирхолтой этгээд**” гэж компанийн эрх бүхий албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.
- 2.5. “**Мэдүүлэг**” гэж ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй этгээдүүд, тэдгээрийн талаар компанийн эрх бүхий албан тушаалтны гаргаж өгсөн мэдээллийг ойлгоно.

## ГУРАВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАХ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ

- 3.1. Энэхүү журамд заасны дагуу дараах албан тушаалтан мэдүүлэг гаргана. Үүнд:
  - 3.1.1. ТУЗ-ийн дарга
  - 3.1.2. ТУЗ-ийн гишүүн
  - 3.1.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
  - 3.1.4. Гүйцэтгэх захирал
  - 3.1.5. Үйл ажиллагаа хариуцсан захирал
  - 3.1.6. Санхүү хариуцсан захирал
  - 3.1.7. Ерөнхий нягтлан бодогч
  - 3.1.8. Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад шууд болон шууд бусаар оролцдог бусад этгээд
- 3.2. Энэхүү журмын 3.1-д заасан этгээдүүд дараах албан тушаалтнуудад мэдүүлгээ гаргана. Үүнд:
  - 3.2.1. ТУЗ-ийн дарга - ТУЗ-ийн бусад гишүүдэд
  - 3.2.2. ТУЗ-ийн гишүүн - ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад
  - 3.2.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга – ТУЗ-ийн даргад
  - 3.2.4. Гүйцэтгэх захирал – ТУЗ-д



- 3.2.5. Бусад эрх бүхий албан тушаалтан – Гүйцэтгэх захиралд тус тус мэдүүлгээ гаргана.
- 3.3. Мэдүүлгийг бүртгэн хүлээж байгаа албан тушаалтан хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах бөгөөд нууцын баталгаа гаргана.
- 3.4. Мэдүүлэгт дараах зүйлийг тусгана. Үүнд:
- 3.4.1. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал – хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичих бөгөөд үүнд гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа гэр бүлийн гишүүн хамаарна.
- 3.4.2. Хувийн ашиг сонирхлын байдал – Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүний албан тушаал эрхэлдэг эсэх талаар мэдээллийг тусгана.

### **ДӨРӨВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ МЭДЭГДЭХ, ТАЙЛБАРЛАХ, ЗОХИЦУУЛАХ**

- 4.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдохдоо Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг гаргана. Мэдүүлэгт тусгагдсан мэдээлэл өөрчлөгдөх тухай бүрд журмын 3.2-д заасан этгээдүүдэд мэдэгдэнэ.
- 4.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай журмын 3.2-д дурдагдсан этгээдүүдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 4.3. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох албан тушаалтанд мэдээлж болно.
- 4.4. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.
- 4.5. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргана.
- 4.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэх үндэслэл бий болсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд саналын эрхгүй оролцох ба тайлбар гаргах эрхтэй.
- 4.7. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанитай ашиг сонирхлын зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлж “Нууцын гэрээ” байгуулна.

### **ТАВ. БУСАД ЗҮЙЛ**

- 5.1. Энэхүү журамд ТУЗ-ийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд журмын хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 5.2. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээллийг цаг тухай бүрд нь гаргаж өгөөгүй эсхүл уг журмыг зөрчсөн гэм буруутай этгээдээр зөрчилтэй байдлаас болж үүссэн хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНОС ХҮНС ХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ  
НЭГДМЭЛ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ**



**1. МЭДҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

- 1.1. Ургийн овог: \_\_\_\_\_
- 1.2. Эцэг/эхийн нэр: \_\_\_\_\_
- 1.3. Өөрийн нэр: \_\_\_\_\_
- 1.4. Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_
- 1.5. Төрсөн аймаг, хот: \_\_\_\_\_
- 1.6. Регистрийн дугаар : \_\_\_\_\_
- 1.7. Оршин суугаа хаяг: \_\_\_\_\_
- 1.8. Утасны дугаар: \_\_\_\_\_
- 1.9. И-мэйл хаяг: \_\_\_\_\_
- 1.10. Эзэмшиж буй МFC хувьцааны тоо: \_\_\_\_\_



**2. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДСОН ТУХАЙ**

Байгууллагын нэр:	
Харьяалах газар, хэлтэс, нэгжийн нэр:	
Албан тушаал:	
Тухайн албан тушаалд томилогдсон огноо:	
Мэдүүлэг гаргах үндэслэл:	<input type="checkbox"/> анх удаа мэдүүлэх <input type="checkbox"/> шинээр томилогдсон <input type="checkbox"/> мэдүүлэгт өөрчлөлт оруулах
Одоо ажиллаж байгаа болон сүүлийн 3 жил ажилласан байгууллага, албан тушаал:	
Таны одоогийн хашиж байгаа ажил, албан тушаал төрийн албанд хамаардаг бол аль төрөлд хамаарахыг сонгоно уу	<input type="checkbox"/> төрийн улс төрийн албан тушаал <input type="checkbox"/> төрийн захиргааны албан тушаал <input type="checkbox"/> төрийн тусгай албан тушаал <input type="checkbox"/> төрийн үйлчилгээний албан тушаал

**3. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ /зөвхөн гэр бүлийн бүртгэлд бүртгэлтэй хүмүүсийг бичнэ/**

Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Төрсөн аймаг, хот, сум	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, эрхэлж буй албан тушаал	Эзэмшиж буй МFC хувьцааны тоо

**4. МЭДҮҮЛЭГЧТЭЙ ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД /өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах эгч, дүүг бичнэ/**

Ямар хамааралтай болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, эрхэлж буй албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Эзэмшиж буй МFC хувьцааны тоо

**5. НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД** /ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ/

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүний нэр	Ямар харилцаатай болох	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа байгууллага, эрхэлж буй албан тушаал	Тайлбар (үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй MFC хувьцааны тоо
Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хуулийн этгээдийн нэр	Ямар хамааралтай болох	Регистрийн дугаар	Эрхэлж байгаа үйл ажиллагааны төрөл	Тайлбар (үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй MFC хувьцааны тоо

**6. КОМПАНИ, БУСАД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан	Ногдол хувь

..... овогтой ..... миний бие өөрийн нэгдмэл сонирхлын байдлыг үнэн зөв мэдүүлсэн бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84.4-т заасан дараах үүргийг чандлан сахиж ажиллахаа баталж байна. Үүнд:

1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;
2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, КТХ болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;
3. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;
4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх;
5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;
6. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх

БАТАЛГААТ ГАРЫН ҮСЭГ: .....

ОГНОО: .....